



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/82

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1, 8.4, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2016 оны "Иргэний харьяалал, шилжилт хөдөлгөөний хяналтын улсын байцаагчийн дүрэмт хувцас, ялгах тэмдэг хэрэглэх журам батлах тухай А/177 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх журам"-ыг нэгдүгээр хавсралтаар, албан хаагчдын дүрэмт хувцасны эдэлгээний хугацааг хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Энэ тушаал батлагдсантай холбогдуулан Гадаадын иргэн, харьяатын газрын даргын баталсан 2017 оны А/376 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар /Д.Давааням/, Санхүүгийн хэлтэс /Ж.Солонго/-т тус тус даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

170000349

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оны ...A/82... дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН
ДҮРЭМТ ХУВЦАС ӨМСӨХ, ХЭРЭГЛЭХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Гадаадын иргэн, харьяатын газар, түүний харьяалах хилийн боомт, орон нутаг дахь нэгж /цаашид “Байгууллага” гэх/-ийн албан хаагчдын дүрэмт хувцас, ялгах тэмдгийг зориулалтын дагуу өмсөх, хэрэглэхтэй холбогдох харилцааг энэхүү журмаар зохицуулна.

Хоёр. Дүрэмт хувцас, ялгах тэмдгийн зориулалт, ангилал

2.1. Дүрэмт хувцас, ялгах тэмдгийг албан хаагч зөвхөн ажлын байранд болон албан үүрэг гүйцэтгэх, хурал, зөвлөгөөн, сургалт, баяр ёслолын арга хэмжээнд оролцох үед журамд заасны дагуу иж бүрдлээр нь цэвэр, үзэмжтэй өмсөж хэрэглэнэ.

2.2. Төрийн захиргааны албан хаагч дүрэмт хувцас өмссөн үед энгэрийн жетоныг зүүж, ажлын үнэмлэхийг /жетонтой/ биедээ авч явах бөгөөд төрийн үйлчилгээний албан хаагч энгэрийн жетон хэрэглэхгүй.

2.3. Дүрэмт хувцсыг ёслол албаны, хээрийн, өвлийн гэж ангилна.

2.4. Ёслол албаны дүрэмт хувцсыг албан ёсны баяр, ёслолын ажиллагаа, хурал, зөвлөгөөн, хүндэтгэлийн болон гадаад, дотоод арга хэмжээнд оролцох, шагнуулах, албан тушаалд томилогдох болон өдөр тутамд албан үүргээ гүйцэтгэх үед өмсөнө.

2.5. Хээрийн болон өвлийн хувцсыг хилийн боомт, орон нутагт ажиллах, хяналт шалгалт, дадлага, сургалт хийх үед өмсөнө.


2.6. Өвөл, зуны хувцасны иж бүрдлийг сольж өмсөх хугацааг төвд байгууллагын дарга, орон нутагт тухайн нэгжийн дарга цаг агаарын нөхцөл байдалд уялдуулан шийдвэрлэнэ.

2.7. Зарим нэгжийн албан хаагчид чиг үүргийн дагуу тусгай зориулалтын хувцас, хэрэгсэл олгож болно.

Гурав. Дүрэмт хувцас, ялгах тэмдгийн иж бүрдэл

3.1. Дүрэмт хувцас нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:

- 3.1.1. малгай /ёслолын, саравчтай, ноосон/;
- 3.1.2. ёслол албаны хувцас /хүрэм, өмд, богино банзал/;
- 3.1.3. хээрийн хувцас /хүрэм, өмд/;
- 3.1.4. өвлийн хувцас /хүрэм, өмд/;
- 3.1.5. цамц /урт, богино ханцуйтай цамц/;
- 3.1.6. ноосон цамц;
- 3.1.7. поло цамц /футболка/;



- 3.1.8. зангиа;
- 3.1.9. бээлий /савхин, цагаан/;
- 3.1.10. агсамж /тоногтой суран бүсний иж бүрдэл/;
- 3.1.11. өмдний тэлээ;
- 3.1.12. гутал /хагас түрийтэй өвлийн болон хавар, намрын/;
- 3.1.13. төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын хувцас /жолооч, үйлчлэгч, сантехникч, цахилгаанчин, мужаан/.

3.2. Ялгах тэмдэг нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:

- 3.2.1. акселвант;
- 3.2.2. зангианы хавчаар;
- 3.2.3. бэлгэ, тэмдэг /ханцуйн, малгайн/;
- 3.2.4. жетон;
- 3.2.5. энгэрийн тэмдэг
- 3.2.6. нэрийн бичиглэл /байгууллагын болон албан хаагчийн нэр/

Дөрөв. Дүрэмт хувцас, ялгах тэмдэг өмсөх, хэрэглэх

4.1. Малгай.

4.1.1. ёслолын малгайг ёслол албаны хүрэм, өмд, богино банзалтай хослуулан өмсөнө;

4.1.2. саравчтай малгайг хавар, намар, зуны улиралд хээрийн хувцастай хослуулан өмсөж хэрэглэнэ;

4.1.3. өвлийн улиралд ноосон малгайны "IMMIGRATION" бичвэрийг зүүн хэсэгт байрлуулсан байдлаар, өвлийн хувцастай хослуулан өмсөнө;

4.1.4. малгайг өмсөхдөө саравч, ирмэгийг хөмсөгнөөс дээш 2 см-ийн зайтай тэгш өмсөнө;

4.1.5. ажлын байранд болон сургалт, хурал, зөвлөгөөний үед малгай өмсөхгүй байж болно.

4.2. Ёслол албаны хувцас нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:


- 4.2.1. малгай;
- 4.2.2. хүрэм;
- 4.2.3. өмд /богино банзал/;
- 4.2.4. цагаан цамц /урт ханцуйтай/;
- 4.2.7. зангиа;
- 4.2.8. бээлий /цагаан/;
- 4.2.9. өмдний тэлээ;

4.3. Ёслол албаны хувцсыг хар өнгийн ботинк, туфль /эмэгтэй албан хаагч түрийтэй хар гутал/-тай хослуулан өмсөнө;

4.4. Акселвант, ёслолын цагаан бээлийг ёслолын арга хэмжээний үед ёслол албаны хувцастай хослуулан хэрэглэнэ;

4.5. Эмэгтэй албан хаагчийн богино банзалны хормойн ирмэг нь өвдөгнөөс дээш 2 см-ийн зайтай байна;

4.6. Эмэгтэй албан хаагч батлагдсан загварын өмд өмсөж болно.



4.7. Богино банзлыг өмсөх тохиолдолд биеийн болон хар өнгийн трикотой хослуулан өмсөнө.

4.8. Хээрийн хувцас нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:

- 4.8.1. малгай /саравчтай/;
- 4.8.2. хүрэм
- 4.8.3. өмд
- 4.8.4. гутал /хагас түрийтэй/;
- 4.8.5. агсамж /тоногтой суран бүсний иж бүрдэл/;
- 4.8.6. поло цамц /футболка/;

4.9. Хээрийн хувцсыг хавар намрын улиралд саравчтай малгай, поло цамц, ноосон цамц, хагас түрийтэй гутал /хавар, намрын/-тай хослуулан хэрэглэнэ.

4.10. Өвлийн хувцас нь дараах иж бүрдэлтэй байна. Үүнд:

- 4.10.1. малгай /ноосон/;
- 4.10.2. хүрэм;
- 4.10.3. ноосон цамц;
- 4.10.4. өмд;
- 4.10.5. гутал /хагас түрийтэй/;
- 4.10.6. бээлий /савхин/

4.11. Өвлийн хувцсыг өвлийн улиралд ноосон малгай, поло цамц, ноосон цамц, хагас түрийтэй өвлийн гуталтай хослуулан хэрэглэнэ.

4.12. цамц /срочка, ноосон, поло/, зангиа, зангианы хавчаар

4.12.1. срочкан цамцны зах нь ёслол албаны хүрэмний захны түвшинд эсвэл дээш цухуйсан байдлаар, хар өнгийн зангиа, хавчаарын хамт өмсөж хэрэглэнэ;

4.12.2. зуны богино ханцуйтай цамц /цагаан, хар/-ыг албан үүрэг гүйцэтгэхдээ зангиагүйгээр өдөр тутам өмсөж болно;

4.12.3. зангиаг ёслол албаны хувцас, ханцуйтай срочкан цамцтай хослуулан хэрэглэх бөгөөд зангианы хавчаарыг цамцны 4-5 дахь товчны хооронд байрлуулна;

4.12.4. ноосон цамцыг хээрийн хувцас, өвлийн хүрэм, өмд, срочкан цамцтай хослуулан өмсөж болно;

4.12.5. поло цамцыг хээрийн хувцас, өвлийн хүрэм өмдтэй хослуулан өмсөнө;

4.13. агсамж, өмдний тэлээ

4.13.1. агсамжийг өвлийн болон хээрийн хувцастай хослуулан хэрэглэнэ;


4.13.2. агсамжийг хээрийн хувцасны гадуур тусгай хэрэгсэл агсах, биедээ авч явах зорилгоор бүсэлж хэрэглэнэ.

4.13.3. өмдний тэлээг ёслол албаны болон хээрийн хувцастай хослуулан хэрэглэнэ.

4.14. Ялгах тэмдэг

4.14.1. хууль сахиулагч тэмдгийг баруун ханцуйд, байгууллагын бэлгэ тэмдгийг зүүн ханцуйд байрлуулсан байна;

4.14.2. ханцуйн тэмдгийг ёслол албаны, хээрийн, өвлийн хүрэмний ханцуйн дээд оёдлоос 8 см, богино болон урт ханцуйтай цамцны ханцуйн дээд оёдлоос 3,5



см зайтай байрлуулсан байна;

4.14.3. дүрэмт хувцасны баруун энгэрт албан хаагчийн нэр, зүүн энгэрт "IMMIGRATION" гэсэн бичвэр бүхий байгууллагын нэрийг байрлуулсан байна;

4.14.4. Жетоныг ёслол албаны болон хээрийн хүрэмний зүүн энгэрийн халаасан дээр байрлуулан зүүнэ.

4.15. Гутал

4.15.1. хагас түрийтэй хавар, намрын гутлыг хээрийн хувцастай, өвлийн хагас түрийтэй гутлыг өвлийн хувцастай хослуулан хэрэглэнэ.

4.16. Хяналтын улсын байцаагч, виз зөвшөөрлийн мэргэжилтэн /орон нутаг дахь/ нь хуульд заасны дагуу ёслол албаны, хээрийн болон өвлийн хувцсыг, ялгах тэмдгийн хамтаар иж бүрэн өмсөж хэрэглэнэ.

4.17. Төрийн захиргааны албан тушаалд ажиллаж байгаа албан хаагчид дараах дүрэмт хувцсыг өмсөж хэрэглэнэ. Үүнд:

4.17.1. малгай /ёслолын/;

4.17.2. ёслол албаны хувцас /хүрэм, өмд, богино банзал/;

4.17.3. цамц /урт, богино ханцуйтай цамц/;

4.17.4. ноосон цамц;

4.17.5. поло цамц /футболка/;

4.17.6. зангиа;

4.17.7. бээлий /цагаан/;

4.17.8. өмдний тэлээ;

4.18. Төрийн үйлчилгээний албан тушаалд ажиллаж байгаа дараах албан хаагч дор дурдсан дүрэмт хувцсыг өмсөж болно. Үүнд:

4.18.1. Ахлах нягтлан бодогч, нягтлан бодогч:

4.18.1.1. малгай /ёслолын/;

4.18.1.2. ёслол албаны хувцас /хүрэм, өмд, богино банзал/;

4.18.1.3. цамц /урт, богино ханцуйтай цамц/;

4.18.1.4. ноосон цамц;

4.18.1.5. зангиа;

4.18.1.6. өмдний тэлээ;

4.18.1.7. бээлий /цагаан/;

4.18.2. Их эмч, нярав, бичиг хэргийн эрхлэгч, бичээч, ахлах архивч—операторч, сан хөмрөгийн эрхлэгч, биеийн тамирын арга зүйч, орон нутаг дахь нэгжийн жижүүр:

4.18.2.1. цамц /урт, богино ханцуйтай цамц/;

4.18.2.2. өмд, богино банзал;

4.18.2.3. ноосон цамц;

4.18.2.4. поло цамц /футболка/;

4.18.2.5. зангиа;

4.18.2.6. өмдний тэлээ;

4.18.3. Мэдээллийн технологийн хэлтсийн албан хаагч, орон нутаг дахь нэгжийн ерөнхий инженер;



- 4.18.3.1. поло цамц /футболка/;
- 4.18.3.2. өмд, богино банзал;
- 4.18.3.3. өмдний тэлээ;


4.19. Шинээр томилогдсон төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албан хаагчид эхний 3 сарын хугацаанд зөвхөн хар, цагаан цамц /урт, богино ханцуйтай/ олгож болно.

Тав. Хориглох зүйл

- 5.1. Дүрэмт хувцсыг ажлын байран дээр болон энэхүү журмын 2.4, 2.5 дах хэсэгт зааснаас бусад тохиолдолд өмсөх;
- 5.2. Дүрэмт хувцас, ялгах тэмдгийг албаны зорилгоос бусад зорилгоор ашиглах, бусдад өмсүүлэх, шилжүүлэх, барьцаалах, худалдах;
- 5.3. Дүрэмт хувцасны өнгө, загварыг өөрчлөх, энгийн хувцастай хольж өмсөх, дүрэмт хувцасны загвараас хасагдсан хувцас, чимэг, хэрэгслийг өмсөж хэрэглэх;
- 5.4. Дүрэмт хувцсыг нөмрөх, энгэр задгай явах, дүрэмт хувцсыг бүрэн бус өмсөж хэрэглэх /товч тасарсан, цахилгаан эвдэрсэн, ханзарч урагдаж цоорсон, ялгах тэмдэггүй зэрэг/;
- 5.5. Дүрэмт хувцсан дээр тусгайлсан чиг үүрэг гүйцэтгэдэг бусад байгууллагын болон гадаад орны цэргийн дүрэмт хувцас, мөрдөс, чимэг хэрэгсэл зэргийг хольж зүүх;
- 5.6. Хээрийн болон ёслол албаны хувцсыг хольж өмсөх;
- 5.7. Албан хаагчид тод өнгөөр үсээ будах, эмэгтэй албан хаагчид үсээ задгай тавих, нүүр, хумсаа этгээд содон, тод өнгийн будгаар будах.

Зургаа. Дүрэмт хувцас олгох, хяналт тавих, хураан авах

- 6.1. Албан хаагчийн дүрэмт хувцасны норм, хангалт, тооцоог байгууллагын санхүү хариуцсан нэгж зохион байгуулж, албан хаагч бүрээр дүрэмт хувцасны карт хөтлөн бүртгэл, тайланд тусгана.
- 6.2. Албан хаагч ажлаас халагдах, чөлөөлөгдөх зэрэг тохиолдолд албаны дүрэмт хувцасны төлбөр тооцоо, тусгай хэрэгсэл, ялгах тэмдгийг санхүү хариуцсан нэгж актаар хураан авна.
- 6.3. Ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн албан хаагчийн дүрэмт хувцсыг хураан аваагүй, холбогдох тооцоог хийж актаар хүлээн аваагүй албан хаагчаар дүрэмт хувцасны үнийг төлүүлнэ.
- 6.4. Хяналтын улсын байцаагч албан үүргээ гүйцэтгэх явцад /тусгайлсан хяналт, шалгалт, албадан гаргах ажиллагааны үеэр/ хэрэглэх боломжгүй болсон хувцасны нөхөн хангалтын зардлыг байгууллага хариуцна.
- 6.5. Эдэлгээний хугацаа дуусаагүй боловч өөрийн буруугаас хэрэглэх боломжгүй болсон дүрэмт хувцас, түүнтэй холбоотой зардлыг тухайн албан хаагч өөрөө бүрэн хариуцна.
- 6.6. Албан хаагчийн ажлаас чөлөөлөгдсөн, халагдсан нөхцөл байдлыг харгалзан удирдлагын шийдвэрээр дүрэмт хувцасны нөхөн төлбөрийг төлүүлж болно.



6.7. Дүрэмт хувцасны төлбөрөөс дараах тохиолдолд чөлөөлөгдөнө. Үүнд:

6.7.1. өндөр насны тэтгэвэр тогтоолгосон;

6.7.2. эрүүл мэндийн шалтгаанаар ажлаас чөлөөлөгдсөн;

6.7.3. нас барсан;

6.7.4. дүрэмт хувцасны эдэлгээний нийт хугацааны 60-аас доошгүй хувьд ашигласан зэрэг;

6.8. Дүрэмт хувцасны нөхөн төлбөрийг тогтоохдоо нормоор тогтоосон хугацаанаас дүрэмт хувцас ашигласан хугацааг хасч, тухайн дүрэмт хувцасны дансны үнийн хувь хэмжээгээр нөхөн төлбөрийг төлнө.

Жишээ нь: Өвлийн хүрэм, өмд 36 сар /нормт хугацаа/ - 12 сар /ашигласан хугацаа/= 24 сар /үлдэгдэл хугацаа/

$(24 \times 100) / 36 = 66.6\%$ / нөхөн төлбөрийн хувь хэмжээ/

$270,000 \times 66.6\% = 179,820$ төгрөг

6.9. Энэхүү журмын хэрэгжилтэд төв болон орон нутаг дахь нэгжийн дарга нар болон дотоод хяналт, аюулгүй байдал хариуцсан албан хаагч өдөр тутмын хяналт тавьж ажиллана.

Долоо. Бусад

7.1. Энэхүү журмыг зөрчвөл сахилгын талонд сануулан тэмдэглэж, сануулгыг 3 удаа авсан албан хаагчид Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулна.

7.2. Албан хаагчид дүрэмт хувцсыг энэхүү журмын дагуу ажил хэрэгч, цэвэр үзэмжтэй өмсөж хэрэглэнэ.

----oOo----

ГАЗДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗАР

ЭХ ХУВЬ... оны... дугаар


ТУШААЛ

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын 2021
оны ...А/82... дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН АЛБАН ХААГЧДЫН
ДҮРЭМТ ХУВЦАСНЫ ЭДЭЛГЭЭНИЙ ХУГАЦАА

д/д	Дүрэмт хувцас	Хугацаа
1	Ёслолын малгай	5 жил
2	Ёслолын хүрэм	3 жил
3	Өмд, богино банзал	1.6 жил
4	Ноосон цамц	3 жил
5	Зангиа	3 жил
6	Малгайн тэмдэг	Хугацаагүй
7	Цагаан цамц /урт ханцуйтай/	1 жил
8	Цагаан цамц /богино ханцуйтай	1 жил
9	Хар цамц /урт ханцуйтай/	1 жил
10	Хар цамц /богино ханцуйтай/	1 жил
11	Поло цамц	3 жил
12	Өмдний тэлээ	3 жил
13	Жетон	Хугацаагүй
14	Агсамж	5 жил
15	Малгай /саравчтай, ноосон/	3 жил
16	Хээрийн хувцас /хүрэм, өмд/	3 жил
17	Гутал /хавар, намрын, өвлийн/	2 жил
18	Өвлийн хүрэм, өмд	3 жил
19	Төрийн үйлчилгээний албан хаагчийн ажлын хувцас	3 жил
20	Тусгай хэрэгсэл	Тус бүрийн үзүүлэлтээс нь хамаарч эдэлгээний хугацааг тодорхойлно.

----oOo----



“Гадаадын иргэн, харьяатын газрын албан хаагчдын дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх журам”-ын нэгдүгээр хавсралт

АЛБАН ХААГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦСАНД ҮЗЛЭГ ХИЙСЭН ТЭМДЭГЛЭЛ



.....онь,.....сарынөдөр
Улаанбаатар хот

Хувцасны иж бүрдэл:

д/д	Хувцас, тусгай хэрэгсэл		Харьяалах нэгж:																	Тайлбар
	Алба хаагчдын нэрс		Ёслолын малгай	Ёслолын хүрэм,	Өмд, богино банзал	Ноосон цамц	Зангиа	Малгайн тэмдэг	Цагаан цамц /урт ханцуйтай/	Цагаан цамц /богино ханцуйтай	Хар цамц /урт ханцуйтай/	Хар цамц /богино ханцуйтай/	Поло цамц	Өмдний тэлээ	Жетон	Малгай /саравчтай, ноосон/	Хээрийн хувцас	Гутал /хавар, намрын, өвлийн	Өвлийн хүрэм, өмд	
1.																				
2.																				
3.																				
4.																				

Жиш: Зөрчил илэрсэн болон албанаас тавьж олгоогүй, байхгүй тохиолдолд “ + ”, зөрчилгүй тохиолдолд “ - ” тэмдэгээр тэмдэглэнэ.

ҮЗЛЭГ ХИЙСЭН:

/ Албан тушаал /

/ Гарын үсэг /

/ Нэр /



..... АЛБАН ХААГЧДЫН ДҮРЭМТ ХУВЦАСНЫ БҮРТГЭЛИЙН МАЯГТ
/Газар, хэлтсийн нэр/

Овог Нэр Албан тушаал

Гаднаадын иргэн, харьяатын газрын алба
хаагчдын дүрэмт хувцас өмсөх, хэрэглэх
журал"-ын хоёрдугаар хавсралт

Үзүүлэлтүүд	Нэр төрөл	Малтай				Бээлий		Цагаан цамц		Хар цамц		Гутал		Албан хаагчийн гарын үсэг														
		дамран	ноосон	саравчтай /зуны/	саравчтай /өвлийн/	цагаан	савхин	ханцуйтай	ханцуйгүй	ханцуйтай	ханцуйгүй	хавар, намар	өвөл	Ёслол албаны хүрэм	Юбка, өмд	Хээрийн хувцас	Өвлийн хүрэм, өмд	Богино хүрэм	Ноосон цамц	Поло футболк	Четон	Зангиа	Зангианы хавчаар	Захны тэмдэг	Ялгах тэмдэг	Аксалвант	Тэлээ	
Эдэлгээний хугацаа																												
Размер, хэмжээ																												
Эхний үлдэгдэл	Тоо хэмжээ																											
	Олгосон он, сар, өдөр																											
Тухайн онд олгосон	Тоо хэмжээ																											
	Олгосон сар, өдөр																											
Тухайн онд хасалт хийсэн	Тоо хэмжээ																											
	Хасалт хийсэн сар, өдөр																											
Эцсийн үлдэгдэл	Тоо хэмжээ																											
	Олгосон сар, өдөр																											

20..... Оны сарын өдөр

БҮРТГЭЛ ХӨТӨЛСӨН: ЭД ХАРИУЦАГЧ

ЭХ ХҮҮЛЬ..... ОНЫ ДУГААР
ТУШАЛ